



НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн менежер шалгаруулж авна.

Төслийн зорилго: Төслийн зорилго нь хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас тавьсан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

1. Хөдөө аж ахуй, эдийн засаг, менежмент, маркетинг, төрийн удирдлага, нийгмийн хөгжил, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой байх
2. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын удирдах албан тушаалд 3-с доошгүй жил ажиллаж байсан туршлагатай байх
3. Англи хэлний ярианы болон бичгийн өндөр түвшний мэдлэгтэй./өөр бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно/
4. Засгийн газар болон хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн бодлого, журам, жендэр, байгаль орчин, авлига, төслийн удирдлага болон санхүүгийн талаар ерөнхий мэдлэгтэй.
5. Мэдээллийн технологи Хэрэглээний программ, цахим орчинд ажиллах мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх

Сонгон шалгаруулалтад орох иргэнийг бүртгэх

Сонгон шалгаруулалтад орох иргэний баримт бичгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын 704 тоот өрөөнд 2018 оны 06 дугаар сарын 06 -ны өдрийн 17:30 цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ.

Сонгон шалгаруулалтад орох иргэн дор дурдсан баримтбичгийг бүрдүүлж, өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

- Төрийн албан хаагчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Холбогдох бичиг баримтын хуулбар (боловсролын диплом, иргэний үнэмлэх, хэлний түвшин тодорхойлсон бичиг баримт)
- Ажилласан жилийг тооцох Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны хуулбар, эх хувийн хамт/;

Сонгон шалгаруулалтын талаарх мэдээлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын 51-261908 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

Эхний шалгаруулалтад тэнцсэн иргэдэд сонгон шалгаруулалт явуулах хугацааг утсаар мэдээлэх болно.